МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2024.07.16 № 03

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР, ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ Б.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

Монгол Улсын Ерөнхий аудитороос Эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар холбогдох мэдээлэл, баримт бичгийг шилжүүлсэн талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1.Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт заасны дагуу шалгуулахаар прокурорын байгууллагад хүргүүлсэн мэдээлэл, тэдгээрийн шийдвэрлэлт;

2.Нийтийн албан тушаалтан хуулиар олгосон бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан буюу авлигын гэм хэрэгт тавьсан хяналт, яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн хэрэг, тэдгээрийн шийдвэрлэлт;

3.Прокурорын байгууллагаас хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн дээрх ажлын тоо, мэдээллийг 2020-2024 оны эхний хагас жилийн байдлаар

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлж, холбогдох Байнгын хорооны хуралдаанд танилцуулахад бэлтгэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН О.АЛТАНГЭРЭЛ

2024000011